

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар: 13

Улаанбаатар хот

**Төлөвлөгөө шинэчлэн
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 3 дугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 4.3, 4.4, 4 дүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-ын 2.1, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагын дагуу “Үндэсний давхар даатгал” ХК-ийн даатгалын нөөц сан болон алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулах 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “...2023 оны төлөвлөгөөг батлах тухай” 31 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолыг 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ